

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЧОЙР 2024 ОН

АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО	3
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	3
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	4
3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ	4
3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	6
3.3.Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ	7
3.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	7
3.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	8
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	10
4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	10
4.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	10
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	11
5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	11
5.2.Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ	12
5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.....	12
ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	13
6.1. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ	13
ДОЛОО. ДҮГНЭЛТ	13
НАЙМ. ЗӨВЛӨМЖ	13

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЗОРИЛГО

Аймгийн эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажил нь бүх шатанд ажлын хариуцлага сахилгыг өндөржүүлэх, санаачлагыг өрнүүлэх замаар амжилтыг бататгах, хүндрэл бэрхшээлийг арилгаж иргэдэд үйлчлэх, төрийн үйлчилгээнд чанарын ахиц дэвшил гаргах, бодлогын зорилтууд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулахад оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжаар батлагдсан “Баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”¹, байгууллагын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхдээ Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлав.

Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх журмын 6.2.1-д зааснаар хувиар илэрхийлэн үнэлсэн, харин тоо, чанараар илэрхийлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг мөн журмын 6.2.2т заасан аргачлалаар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг дээрх журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

Үнэлгээ хийх журамд заасны дагуу ерөнхий үнэлгээг тооцохдоо:

✓ бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд орсон 6 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 50 хувь;

✓ байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд орсон 3 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 15 хувь;

✓ байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд орсон 4 үзүүлэлтийн дундаж нь нийт үнэлгээний 20 хувь;

✓ Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд орсон 1 үзүүлэлт нь нийт үнэлгээний 15 хувь болно.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт;
- Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд:

- Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт;
- Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт.

Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд:

- Байгууллагын ил тод байдал;
- Шилэн дансны хөтлөлт;
- Шударга байдлын түвшний үнэлгээ;

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээнд:

Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дүн зэрэг 11 үзүүлэлтийг тооцсон.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ цаасан болон цахим тайланд тулгуурласны зэрэгцээ бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэлтэй зохих харьцуулалт хийж, 2023 оны хагас жилээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын эрхлэх асуудлын хүрээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар хууль болон Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг нийт 52 зүйл, заалтын хэрэгжилтийг хянаж 94.6 хувиар үнэлэв.

Хүснэлт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, 2023 он

Эрх зүйн актын төрөл	Нийт	Үнэлгээ /заалтын тоо/				Дундаж үнэлгээ /%/
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	
		100%	70%	30%	0%	
Монгол Улсын хууль	28	26	2			97.9
Ерөнхийлөгчийн зарлиг	7	6	1	-	-	95.7
Засгийн газрын тогтоол	10	7	2	1	-	87.0
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	2	1	-	-	90.0
Засгийн газрын албан даалгавар	4	3	1	-	-	92.5
Нийт	52	44	7	1	-	94.6
Үнэлгээнд эзлэх хувь	100	84.6	13.5	1.9	0	

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн холбогдох заалтуудаас хэрэгжилт хангалтгүй хангалтгүй 1 заалт байна. Үүнд:

Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын 5 дахь заалт “Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын

цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх”;

3.2. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тус агентлагт хэрэгжүүлэх 10 арга хэмжээ байгаагаас 10 арга хэмжээг хэрэгжүүлж 2023 оны хэрэгжилтийг 88.1 хувиар үнэлэв.

3.3. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус агентлагт хэрэгжүүлэх 15 арга хэмжээ байгаагаас 9 арга хэмжээг хэрэгжүүлж 2023 оны хэрэгжилтийг 89.03 хувиар үнэлэв.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд тайлагнах шаардлагатай 6 арга хэмжээ байна. Тухайлбал:

- 1) 2.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэгш, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.
- 2) 2.6.7. Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, хамтран ажиллана.
- 3) 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4) 4.1.2. Төрийн архивын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 5) 4.2.1. Нутгийн захиргааны байгууллагуудыг чадавхжуулан, төрийн үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг сайжруулж, шаардлагатай барилга, техник, тоног төхөөрөмжөөр хангана.
- 6) 4.2.3. Төрийн албыг мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагаа явуулах, төрийн албаны залгамж чанарыг хангах, төрийн албан хаагчдын манлайлал, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх төрийн албанд шатлан дэвших нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Эрчимжүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. 3.1.2. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай болгон, төсвийн урсгал болон гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4. Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөөнд тус агентлагт хэрэгжүүлэх 13 арга хэмжээ байгаагаас 2 арга хэмжээг хэрэгжүүлж 2023 оны хэрэгжилтийг 93.3 хувиар үнэлэв.

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд тайлагнах шаардлагатай 11 арга хэмжээ байна. Тухайлбал:

1. 2.5.3 Хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээний иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.
2. 2.6.6 Орон нутагт соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхжуулна.
3. 2.6.7 Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана.
4. 4.1.1.1 Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлж, мэдээллийн ил тод аюулгүй байдлыг хангана.
5. 4.1.1.2 “Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, төрийн үйлчилгээг цахимжуулах” арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
6. 4.1.1.3 Тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэнэ.
7. 4.2.3.4 Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн албаны хуулийн хүрээнд мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.
8. 4.2.3.5 Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хуулийн хүрээнд сул орон тоог нөхнө.
9. 4.2.4.8 Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.
10. 7.1.16.38 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, аймаг, сумдын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгож иргэд олон нийтийн оролцоог хангана.
11. 7.1.17.43 Төрийн үйлчилгээг цахимжуулж, тоон гарын үсгийг нэвтрүүлж, иргэдэд сурталчилна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд 5 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан үзэж, 93.6 хувиар үнэлэв.

№	Чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь						Дундаж үнэлгээ %/
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
					100	90	70	50		
1	Стратеги болон бодлогын баримт	2	8	4		4				86.2

	бичигт тусгагдсан зорилт								
2	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт	1	2	2					100.0
3	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	20	10	7		3		90.2
4	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	1	1	1					97.9
	Нийт	5	31	17	7	4	3		93.6

4.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, 95.0 хувиар үнэлэв.

1. Хүний нөөцтэй холбоотой тушаал, шийдвэрийн хуулийн үндэслэлд анхаарах.
2. Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системд бүх албан хаагчдыг бүртгэж, байгууллагынхаа дотоод үйл ажиллагаанд ашиглаж, ашиглалтыг сайжруулах.
3. Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлангийн чанарт анхаарах.
4. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах
5. Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэх, баяжуулах

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 6 төрлийн 43 мэдээлэл тус бүрээр хянан үзэж, 95.0 хувиар үнэлэв.

Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (мэдээллийн төрлөөр) Тус байгууллага мэдээллийг хугацаандаа бүрэн бүтэн байршуулсан байх.

5.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны шилэн данс хөтлөлтөд 11 дүгээр сарын байдлаар 165 удаа мэдээлэл байршуулахаас 160 удаа мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийн хугацаа хоцроосон байна. Шилэн данс хөтлөлтийн үнэлгээ 98.5 хувь үнэлэв.

Мэдээлэл байршуулах давтамжийн тоо	байршуулах	165
Хугацаанд нь мэдээлэл байршуулсан байдал	байршуулсан	162
	хугацаанд нь байршуулсан	160
	хугацаа хоцроосон	2
Үнэлгээний %		98.5

5.3. Шударга байдлын түвшний үнэлгээ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын гаргасан тушаалын Төрийн аудитын газарт хянуулахаар өгсөнөөс бусад тушаалын хууль, эрх зүйн үндэслэл, Авлигын эсрэг төлөвлөгөөний 6 арга хэмжээний хэрэгжилтийг хянахад:

Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
Байгууллагаас гарсан шийдвэрийн хуулийн хэрэгжилт	100.0
Нийт дүн	89.0
	94.5

ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

6.1. Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ 90.0 хувь байна.

№	Үнэлгээ	Ногоон байгууламж	Цахим шилжилт	Хог хаягдлын менежмент
1	Зорилтын тоо	1	1	1
2	Шалгуур үзүүлэлтийн тоо	3	43	5
3	Бүрэн хэрэгжсэн /90-ээс дээш/	2	40	2
4	Бүрэн хэрэгжээгүй /90-ээс доош/	1	3	3
5	Хугацаа болоогүй	-	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн		90.0	95.0	85.0

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тус байгууллагын бодлогын баримт бичгийн болон хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналтшинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэв.

Говьсүмбэр аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 90.82 хувь, Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 93.37 хувь, Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 96.0 хувь, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт 92.5 хувь, ерөнхий үнэлгээ 93.4 хувь байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 1 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн нийт 18 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, 2024 оны төлөвлөгөөнд нэмэлтээр тусган хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, сахилга хариуцлагыг дээшлүүлэх нь зүйтэй байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуульд заасан мэдээллийг ил тод, нээлттэй болгож, иргэдийг үнэн зөв, бүрэн, ойлгомжтой мэдээллээр хангах, мэдээллийн үйлчилгээг шуурхай, хялбар болгоход анхаарч, хуулийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт		Үнэлгээ		
			Хувь	Жин	оноо
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.	94.67	0.5	0.45
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	89.0		
		3.Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт.	88.1		
		4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт.	89.03		
		5.Говьсүмбэр аймгийг хөгжүүлэх 2023 оны жилийн төлөвлөгөө	94.1		
		6.Шинэ сэргэлтийн бодлого.	90.0		
		7. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт	-		
		Дундаж	90.82		
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.	-	0.15	0.14
		2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	93.4		
		3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт.	95.0		
		4. Аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагч нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт.	95.3		
		5. Зөвлөмжийн хэрэгжилт	93.47		
		Дундаж	93.37		
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.	95.0	0.2	0.19
		2.Шилэн дансны хөтөлбөрийн үнэлгээ.	98.5		
		3.Шударга байдлын түвшин -Ажилтын эсрэг төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт -Тушаал, шийдвэр.	94.5		
		4.Хэрэглэгчийн үнэлгээ	-		

4	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Дундаж			
		1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт. -Ногоон байгууламж (Мод тарих) -Цэцэрлэг -Хог хаягдлын менежмент	96.0	0.15	0.14
		2.Нээлттэй Говьсүмбэр	90.0		
		Дундаж	100.0		
			Дундаж	92.5	
Ерөнхий үнэлгээ			1.0	93.4	

НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Говьсүмбэр аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн цаашид дор дурдсан асуудалд анхаарал хандуулж, удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Зөвлөмж болгож байна.

Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах талаар:

1. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээг үр дүнд чиглүүлж, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг тодорхой, оновчтой, үр дүнг илэрхийлэхүйц, хэмжих боломжтой байдлаар тодорхойлох;
2. Бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, түүний эх үүсвэрийг үндэслэл, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх;

Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах.
2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах.
3. Төсвийн байгууллагуудын санхүүгийн зөрчлийг арилгах, эрсдэлийг бууруулах, зөвлөн туслах үйл ажиллагааны үр дүнг сайжруулах.
4. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутаг болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр идэвх санаачлага гарган ажиллах.
5. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, тухайн жилийн хэрэгжилтийг бүрэн хангах;
6. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хэрэгжилтийг үр дүнд чиглүүлэн зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах;
7. Монгол Улсын хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудтай хамтарч ажиллах.

Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах арга хэмжээ авч ажиллах;
2. Аймгийн ЗДТГ-ын даргын 2023.11.13-ны өдрийн 01/1130 дугаартай албан бичгийг хариуг ирүүлсэн боловч албан бичигтэй холбоотой тусгайлан хийж хэрэгжүүлсэн ажлын талаар бус Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг ирүүлсэн байх тул тусгайлан зохион байгуулсан арга хэмжээний талаарх тайланг ирүүлэх.
- 3.Тушаал шийдвэр гаргахдаа хүчингүй болсон хууль тогтоомжийг үндэслэхгүй байх.

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШҮХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА

ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.МӨНХЗАЯА

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ХШҮХ-ИЙН ДАРГА



М.АНХБАЯР

ТАНИЛЦСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СОДНОМ